

**Олон улсын тээвэрлэлтийн үйлчилгээ
Сэдэв: Олон улсын ачаа тээвэрлэлтийн
бусад төрлүүд**

**Улаанбаатар хот
2018 он**

АГУУЛГА

| | |
|--|----|
| 1. Олон улсын ачаа тээвэрлэлтийн бусад төрөл хэлбэрүүд | 3 |
| 2. Дамжуулах хоолойн тээвэрлэлт, түүний онцлог..... | 5 |
| Зураг 1. Дамжуулах хоолойг барих барилгын явц | 7 |
| 3. Холимог тээвэрлэлт, түүний онцлог | 8 |
| <i>Тээвэрлэлтийн хариуцлага:</i> | 10 |
| Ашигласан эх сурвалжийн жагсаалт | 12 |

1. Олон улсын ачаа тээвэрлэлтийн бусад төрөл хэлбэрүүд

Агаарын, автозамын, төмөр замын, далайн тээвэрлэлтүүд дангаараа орчин үеийн олон улсын худалдаанд ашиглагдахаас гадна дээрх хэлбэрүүд холимог байдлаар хэрэглэгдэх нь элбэг тохиолддог. Ийм хэлбэрийн тээвэрлэлтийг олон улсын хэмжээнд олон төрөлт тээвэрлэлт (multimodel) буюу холимог тээвэрлэлт гэж нэрлэж байна.

Олон төрөлт тээвэрлэлт нь тээврийн 2 ба түүнээс дээш төрөл хэлбэрүүдийг ашиглан алс хол зайд явагддаг тул тээвэрлэлтийн онцгой горимыг шаарддаг.

Олон төрлийн тээврийн хэрэгслээр дамжин тээвэрлэж буй барааг тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачих буюу сэлгэн ачих тухай бүрт, эсвэл гаалийн болон бусад хяналт шалгалтаар олон дахин оруулж түүний тээврийн баримтыг солих нь цаг хугацаа алдах болон бусад бэрхшээлтэй байдлыг бий болгодог. Энэ бэрхшээлийг тойрон гарахын тулд ачааны чингэлэгийг олон улсын тээвэрлэлтэд өргөнөөр ашиглах болсон.

Олон улсын стандартын байгууллага (International Standard Organization ISO) -аас батлан гаргасан нэг загварын 3, 5, 10, 20, 30, 40, 60 тоннын чингэлэгүүдийг олон улсын тээвэрлэлтэд ашиглаж байна. Чингэлэгийг ашигласнаар тээвэрлэлтийн үеийн дээрх бэрхшээлтэй байдлыг арилгаж, төрөл бүрийн тээврийн хэрэгсэлд чингэлэгийг ачих, сэлгэн ачих, буулгах механизмуудыг төдийгүй тээврийн хэрэгслүүдийн чингэлэг ачих тавцанг нэг стандартад оруулсан. Ингэснээр цаг хугацаа, зардал хэмнэх бодит боломж бий болсон.

Олон төрөлт тээврийн хөгжилтэй уялдаатайгаар түүнийг олон улсын хэмжээнд зохицуулах эрхзүйн механизм үүсэн хөгжиж байна.

Экспорт, импортын ачаа барааг тээвэрлэх дээрх хэлбэрүүдээс гадна гол мөрний, дамжуулах хоолойн, цахилгааны шугам г.м тээвэрлэлтийн олон хэлбэрүүд бий.


Дамжуулах хоолойн тээврийг нефть шатдаг хий г.м зүйлсийг тээвэрлэхэд ашиглаж байна.

Тээвэрлэлтийг хамгийн хямд өртөг зардлаар үйлддэг дамжуулах хоолойн тээвэрлэлт сүүлийн жилүүдэд огцом өсөх хандлагатай байгаа юм.

1970 онд нефть дамжуулах хоолойн нийт урт 258000 км, хий дамжуулах хоолойнх 609000 км байсан бол 2000 онд эдгээрийн нийт урт нь харгалзан 500000 км 2000000 км болж өсөн нэмэгджээ.



Цахилгаан эрчим хүчийг цахилгаан шугамаар дамжуулан худалдаалдаг. Мэдээллийн үйлчилгээг интернетийн сүлжээ харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан худалдаалж байна. Орчин үед электрон худалдаа нэлээд өргөн дэлгэр хэрэглэгдэх болсон. Электрон худалдааны гэрээ хэлцэл нь компьютерын сүлжээгээр дамжин хийгддэг боловч барааг нийлүүлэх үйл ажиллагаа нь тээвэрлэлтийн уламжлалт аргуудаар дамждаг.



2. Дамжуулах хоолойн тээвэрлэлт, түүний онцлог

Нефтийг дамжуулах хоолойгоор анх Америкт 1985 оноос тээвэрлэж эхэлжээ.

Дамжуулах хоолойг ашиглан нефть, хийг тээвэрлэхээс гадна зарим нэг хатуу биетийг тухайлбал, чулуун нүүрсийг дамжуулах хоолойн тээвэрлэлт олон улсад ашиглагдаж эхлээд байна. Түүнчлэн нефть, хийн орд газарт цооногуудын болон нефть хийн агуулахуудын холболтын аль эсвэл хуваарилалтын их хэмжээний шугам хоолой ашиглагддаг.

Дамжуулах хоолойн тээвэрлэлт нь дараах өвөрмөц техник эдийн засгийн онцлог, давуу талуудтай.

Давуу тал нь:

- Магистраль шугам хоолойгоор нефть, нефтийн бүтээгдэхүүн олборлож байгаа бүх байгалийн хийг тээвэрлэдэг.
- Нефть, нефтийн бүтээгдэхүүн тээвэрлэх магистраль хоолой нь нефть олборлох, боловсруулах, хэрэглэх бүх төвүүдийг холбоно.
- Магистраль дамжуулах хоолой нь нефть автобензин, дизелийн болон бүх төрлийн хөдөлгүүрийн түлшийг аль ч чиглэлд дамжуулах бололцоог хангана.
- Магистраль дамжуулах хоолойгоор нефть, нефтийн бүтээгдэхүүн түүнчлэн хийг цуваагаар тээвэрлэж болно.
- Магистраль дамжуулах хоолойн ажиллагаа нь газарзүйн болон байгалийн ямар ч нөхцөлд хоног, сар, жилийн турш тасралтгүй ажиллаж хэрэглэгчдэд саадгүй хүргэнэ.
- Дамжуулах хоолойг инженер-геологи, байрзүйн болон цаг уурын ямар ч нөхцөлд байгуулж болно.
- Дамжуулах хоолойн зам /трасс/-эхний болон эцсийн цэгийн хоорондох хамгийн бага зай.
- Дамжуулах хоолойн байгууламж нь богино хугацаанд баригддаг ба нефть, хийн орд газар, хөөрөгдөх станцийн хүчин чадлыг бүрэн эзэмших боломжтой.

- Магистраль дамжуулах хоолой дээр нефть, нефтийн бүтээгдэхүүн, хий хөөрөгдөх үйл ажиллагаанд хэсэгчилсэн болон бүрэн удирдлагын автомат системийг хэрэглэх бололцоотой .
- Дамжуулах хоолойн тээвэрлэлт нь бусад төрлүүдээс хамгийн бага зардалтай.

Сул тал нь:

- Дамжуулах хоолойг байгуулж дууссаны дараа чиглэлийг өөрчлөх боломжгүй.
- Их хэмжээний металл орно.

Түүхий нефть, байгалийн хийг орд газар талбайд цуглуулан хуримтлуулах, боловсруулах үйлдвэр болон томоохон хэрэглэгчдэд хүргэхийн тулд орд газрын хүрээнд богино зайнд, тив дэлхий, бүс нутаг улс гүрнийг дамжуулан алсын замд тээвэрлэх, нефть хийн агуулахуудад хадгалах үйл ажиллагааг явуулах шаардлагатай болдог.

Манай орны хувьд нефтийн бүтээгдэхүүнийг гадаадаас импортлон төмөр замаар вагон цистернээр тээвэрлэн төмөр замын дагуух, нефтийн бүтээгдэхүүний томоохон агуулахуудад /Дархан, Эрдэнэт, Улаанбаатар, Чойбалсан гэх мэт/ тээвэрлэн авчирдаг.

Баруун ба Өмнөд хэсэгт нефтийн бүтээгдэхүүнүүдийг импортлон автоцистернээр тээвэрлэн авчирч байна.

Нефтийн бүтээгдэхүүний дамжуулан хуваарилах болон орон нутгийн агуулахуудаас шатахуун түлш, тос материалыг тархай бутархай хэрэглэгчидтэй өргөн уудам нутаг дэвсгэртэй манай орны хувьд ихэвчлэн автоцистернээр тээвэрлэж жижиг төв суурин газруудад /сум, багийн төв гэх мэт/ хэрэглэгчдэд хүргэдэг.

Нефть, нефтийн бүтээгдэхүүн болон хийг дамжуулах хоолой, төмөр зам далайн болон голын тээвэр, автотээврээр тээвэрлэдэг.

Дэлхийд нефть тээвэрлэх хамгийн хямд зардалтай тээвэрлэлт нь далайн тээвэрлэлт юм.

Өнөөдөр дэлхий дахинд хоолойн тээврийн ач холбогдол улам их өссөөр байгаа бөгөөд дэлхийн эдийн засгийн 13% нь шууд тээврээс хамаардаг гэсэн тооцоо байдаг. Үүнд хоолойн тээвэр нь дараах үүрэгтэйгээр оролцдог.

- Дамжуулах хоолойгоор дамжуулагдах хий ба газрын тос нь өөрөө эрчим хүчний эх үүсвэр буюу тээврийн хэрэгслүүдийг хөдөлгөгч чухал түүхий эд болдог.
- Дамжуулах хоолой нь тасралтгүй урсдаг эрчим хүчийг тээвэрлэхэд бусад төрлийн тээврээс хэдэн зуу дахин хямд байдаг.

Зураг 1. Дамжуулах хоолойг барих барилгын явц



3. Холимог тээвэрлэлт, түүний онцлог

Анх удаа 1956 онд Америкт тээвэрт “контейнер” – ийг ашигласнаар энэ нь нэг ёсны бараа бүтээгдэхүүн тээвэрлэлтийг стандартчилах эхлэл болсон гэж үздэг.

Өнөөдөр “контейнер” – ийг хамгийн үр дүнтэйгээр хэрэглэж байгаа тээврийн систем нь холимог тээвэрлэлт болоод байна.



Контейнерийн тээврийн төрөл:

- ✓ Dry container - Энгийн бүтээгдэхүүн
- ✓ Reefer container - Хөлдөөх шаардлагатай бүтээгдэхүүн
- ✓ Solid bulk container - Үр тариа
- ✓ Open to container - Хүнд ачаа тээвэр
- ✓ Tank container - Химийн бодис, бүтээгдэхүүн
- ✓ Pen container - Амьд амьтан

Standard



Flatracks



High-Cube



Hard-Top



Open-Top



Platforms



Ventilated



Refrigerated



Bulk



Tank



Контейнер тээвэрлэлтийн давуу тал:

- Эдийн засгийн хувьд: Хадгалалт, даатгал, тээврийн зардал бага
- Цаг хугацааны хувьд: Газраар, усаар тогтмол тээвэрлэх системийг бий болгосон.
- Аюулгүй байдлын хувьд: Бат бөх металлаар хийгдсэн.

Контейнерт ачих бараа бүтээгдэхүүн, эд зүйлсийн ангилал:

Дээд зэргийн бараа

Өндөр үнэтэй бараа, овор багатай электрон бараа

Тохирсон бараа

Цахилгаан бараа, ууттай кофе, арьс, нэхий бүтээгдэхүүн

Хязгаартай бараа:

Хүнд төмөр, шахмал мод, ашиг багатай бараа

Үл тохирсон бараа

Бараг боломжгүй бараа /том ачааны машин, багана, төмөр суварга г.м./

1980 оны “Олон Улсын Холимог Тээвэрлэлтийн Гэрээ” хэлэлцээрээр Олон Улсын Холимог Тээвэрлэлт /International Multimodal Transport/ гэдэг нь: “Холимог тээвэрлэгч нь тээвэрлэх бараа бүтээгдэхүүнийг өөрийн биеэр хариуцан ямар нэгэн улсын тодорхой нэгэн орон зайнаас өөр нэг улсын тодорхой нэг орон зай хүртэл холимог тээвэрлэлтийн тухай гэрээнд тулгуурлаж хоёроос доошгүй тээврийн хэрэгслийг ашиглаж тээвэрлэлт хийх” – ийг хэлнэ гэсэн байдаг.

Тээвэрлэлтийн хариуцлага:

Холимог тээвэрлэгч нь тээвэрлэх хугацаанд дайран өнгөрч буй бүх орон зайд бараа бүтээгдэхүүний талаар хариуцлага хүлээх ёстой. Учир нь холимог тээвэрлэгч нь нэг талаар тодорхой гэрээний оролцогч болоод зогсохгүй нөгөө талаар янз бүрийн тээврийн орон зайг хооронд нь холбож ингэснээр бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ болон хангамжинд их үүрэг гүйцэтгэж байна гэсэн үг юм.

Холимог тээвэрлэгчийн хариуцлагын гурван төрлийн систем байдаг. Үүнд:

1. *Нэг хэвийн, хэвшмэл хариуцлагын тухай систем. (Uniform Liability System):* Тээвэрлэх бараа алдагдах, эвдрэх, бохирдох зэрэг нь яг аль орон зайнаас эхэлсэн бэ гэдгээс хамаарахгүйгээр холимог тээвэрлэгч нь нэг л янзын нэгдсэн хэв маягийн дагуу хариуцлага хүлээнэ гэсэн систем юм.
2. *Хэвшмэл биш хариуцлагын тухай систем. (Network Liability System):* Бараа бүтээгдэхүүний гэмтсэн, алдагдсан, бохирдсон орон зай тодорхой болсон тохиолдолд тэр газар нутгийн үндсэн хууль, дүрэм болон олон улсын гэрээ, хэлцлийг үндэслэнэ. Тодорхой болоогүй үед тус хохирлыг тээвэрлэх орон зай хамгийн урт байсан хэсэгт үүссэн гэж үзэж хариуцлагыг тооцдог.
3. *Өөрчлөгддөг хэвшмэл хариуцлагын тухай систем. (Modified Uniform Liability System):* Ерөнхий зарчим бол хохирол гарсан орон зайнаас шалтгаалахгүйгээр нэгдсэн журмыг мөрдөх ба хохирол гарсан орон зай тодорхой болсон тохиолдолд тэр орон зайд мөрдөгдөх хууль журамд заасан хариуцлага хүлээх хэмжээ нь Олон улсын гэрээ хэлцэлд зааснаас өндөр байвал тэр орон зайн хууль журмын дагуу хариуцлагыг хүлээнэ гэсэн үг юм.

Холимог тээвэрлэлтийн баталгаа (Through or Multimodal Transport B/L)

Холимог тээвэрлэлтийн баталгаа гэдэг нь усан замын, төмөр замын, агаараар болон автомашинаар тээвэр хийхэд бараа бүтээгдэхүүн тээвэрлэгч болон хүлээн авагчийн байрлаж буй тус тусын орон зайд хэрэгждэг холимог тээвэрлэлтийн гэрээг батлахын тулд үйлддэг баримт гэж ойлгож болно.

Холимог тээвэрлэлтийг хийхийн тулд холимог тээвэрлэгчийн зүгээс тээвэрлэх орон зайд бүх хариуцлагыг хүлээнэ гэсэн баталгааг гаргах ёстой. Ингэснээр хууль ёсоор тээврийн талаарх хариуцлагыг хялбарчлах боломжтой болж байна гэсэн үг юм.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Батнасан.Н., (2003), “Гадаад худалдаа: Үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт”, хуудас 221-223.
2. <https://www.slideshare.net/grane09/10-19032061>
3. <https://www.slideshare.net/khina/14-42436611>
4. <http://e-book.must.edu.mn/lecture/show/id/718>